



**МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2020 оны 07 сарын 07 өдөр

Дугаар A/370

Ховд


Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.3.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/08 тоот тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Цамбагарав багийн Лааганы 2 дугаар гудамжны 206 б тоотод байрлах, 300 метр квадрат газрыг Даваажавын Баатар /ПЮ50050512/-д үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ